



**ӨМНӨГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2018 оны 01 сарын 12 өдөр

Дугаар 03

Даланзадгад

Г ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 12 дугаар зүйл, 14 дүгээр зүйлийн 14.2, 20 дугаар зүйлийн 20.1.7 дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. “Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгчдийн суудлын мөнгө зарцуулах” журмыг хавсралтаар баталсугай.
2. Журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга /Б.Галхүү/-д даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



Х.СУГИР

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2018 оны 03 дугаар
тогтоолын хавсралт



**Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Төлөөлөгчдийн суудлын мөнгө зарцуулах журам**

Нэг. Нийтлэг үндэслэл

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 12 дугаар зүйл, 14 дүгээр зүйлийн 14.2 дахь заалтад заасны дагуу аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал /цаашид Хурал гэх/-ын Төлөөлөгч бүрэн эрхээ хэрэгжүүлж, сонгогдсон тойрогтоо үр дүнтэй ажиллах, хууль тогтоомж, Хурлын шийдвэрийг суртачлах, түүний хэрэгжилтийг хангуулах, хяналт тавих, иргэд сонгогчидтойгоо байнгын эргэх холбоотой ажиллахад тодорхой хэмжээний төсөв, хөрөнгө шаадлагатай байдаг.

Иймд аймгийн ИТХ-ын Төлөөлөгчид иргэд сонгогчдынхоо өмнө хүлээсэн үүрэг, Төлөөлөгчийн бүрэн эрхээ хэрэгжүүлж ажиллахад шаардагдах зардлыг олгоход энэхүү журмыг мөрдөнө.

Хоёр. Зорилго

Аймгийн ИТХ-ын Төлөөлөгч бүрэн эрхээ үр дүнтэй хэрэгжүүлж, хууль тогтоомж, Хурлын шийдвэрийг суртачлах, түүний хэрэгжилтийг хангуулах, хэрэгжилтэд хяналт тавих, иргэд сонгогчдын санал бодлыг сонсож, байнгын эргэх холбоотой, манлайлан ажиллахад энэхүү журмын зорилго оршино.

Гурав. Суудлын мөнгөний зарцуулалт

3.1. Төлөөлөгчдийн суудлын мөнгийг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тухайн жилийн төсөвт тусган батлуулж, Хурлын даргын Захирамжаар Төлөөлөгчдөд олгож, дараах үйл ажиллагаанд зарцуулна. Үүнд:

3.1.1. Хуулийн төсөл, нийгмийн амьдралын чухал асуудлыг иргэдээр хэлэлцүүлэх, санал асуулга явуулах

3.1.2. Төлөөлөгч нь аймгийн ИТХ-ын хуралдаан болон Тэргүүлэгчдийн хуралд асуудал санаачлан хэлэлцүүлэхдээ, уг асуудлыг иргэдээр урьдчилан хэлэлцүүлэх

3.1.3. Хууль тогтоомж, Хурлын шийдвэрийг иргэдэд суртачлах, түүний биелэлтийг хангуулах, хэрэгжилтэд хяналт тавих

3.1.4. Хурлын дарга болон Хороодын даргаас өгсөн удирдамж, чиглэлийн дагуу аливаа хяналт шалгалт, зохион байгуулалтын үйл ажиллагаанд оролцох

3.1.5. Сонгогдсон тойргийнхоо иргэдээс гарсан өргөдөл, гомдол, санал хүсэлтийг хүлээн авч шийдвэрлүүлэх, хариу өгөх

3.1.6. Төлөөлөгчийн ажлаа тайлагнаж хурал, зөвөлгөөн, семинар, уулзалт, ярилцлагад оролцох, Төлөөлөгчийн чиг үүргээ хэрэгжүүлсэн талаар ном сонин, сэтгүүлд ярилцлага өгч хэвлүүлэх

**Дөрөв. Төлөөлөгчдийн суудлын мөнгөний зарцуулалтын
тайлан гаргах**

4.1 Төлөөлөгч тойрогтоо ажиллах ажлын төлөвлөгөөг хагас, бүтэн жилээр гарган нэгдүгээр сард багтаан аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн ажлын албанд ирүүлнэ.

4.2 Төлөөлөгч тойрогтоо ажилласан үйл ажиллагааны зардлын тайланг улирал бүр гаргаж, гарын үсэг зурж баталгаажуулан аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн ажлын албанд улирлын сүүлийн сарын 20-ны өдрийн дотор багтаан хүргүүлнэ.

4.3 Тухайн улиралд зарцуулсан зардлын дэлгэрэнгүй тайлан мэдээг нягтлан бодох бүртгэлийн хуулийн дагуу гаргасан байна.

4.4. Ажлын төлөвлөгөө, тайланд үндэслэн суудлын мөнгө олгодоно.

Тав. Төлөөлөгчдийн суудлын мөнгөний зарцуулалтын хяналт

5.1. Төлөөлөгчдийн суудлын мөнгөний зарцуулалтад Хурлын дарга болон Санхүүгийн хяналтын алба хяналт тавина.